# ХӨСӨГ ТРЕЙД ХК-ИЙН
# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 04 сарын 29 өдөр Дугаар 01 Улаанбаатар хот

*Санхүүгийн болон үйл ажиллагааны*

*тайлан батлах тухай*

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62.1.9 дэхь заалт, **"ХӨСӨГ ТРЕЙД"** ХК-ийн 2020 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг баталсугай.
2. Компани 2019 онд ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн ТУЗ-ийн тогтоолыг танилцуулсаныг дурьдсугай.
3. Компанийн үйл ажиллагааг идэвхижүүлж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА /Л.МЯГМАРЖАВ/

# ХӨСӨГ ТРЕЙД ХК-ИЙН
# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 04 сарын 29 өдөр Дугаар 02 Улаанбаатар хот

*Компанийн ТУЗ-ийн гишүүдийг*

*сонгох тухай*

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, дахь заалт болон **“ХӨСӨГ ТРЕЙД”** ХК-ийн 2020 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын тогтоолыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийг хугацаанаас өмнө дуусгавар болгосугай.

2. Кумулятив аргаар санал хураасан дүнг үндэслэн дараах нэр бүхий 6 хүнийг Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүнээр сонгосугай.

1. Л.Мягмаржав
2. Д.Нямбаяр
3. Д.Бямбажал
4. Л.Цэгмид
5. Н.Түвшинзаяа
6. Б.Отгонбаатар

3. Кумулятив аргаар санал хураасан дүнг үндэслэн дараах нэр бүхий 3 хүнийг Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр сонгосугай.

1. А.Балжинням
2. С.Мөнхгэрэл
3. Б.Төрсайхан

4. Компанийн тухай хууль болон компанийн дүрмээр тогтоосон үүргээ хэрэгжүүлж, компанийн эрх ашгийн төлөө ажиллахыг гишүүдэд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА /Л.МЯГМАРЖАВ/

# ХӨСӨГ ТРЕЙД ХК-ИЙН
# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 04 сарын 29 өдөр Дугаар 03 Улаанбаатар хот

*Компанийн ТУЗ-ийн цалин урамшууллыг*

*батлах тухай*

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13, дахь заалт болон **"ХӨСӨГ ТРЕЙД"** ХК-ийн 2020 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын тогтоолыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1.Төлөөлөн Удирдах Зөвлөлийн цалин урамшууллыг доорхи хувь хэмжээгээр баталсугай.

Үүнд:

1. ТУЗ-ийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүдийн нэг сарын цалинг Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцож олгосугай.

2 ТУЗ-ийн дарга, нарийн бичгийн дарга, ердийн болон хараат бус гишүүдийн урамшууллыг доорхи хувь хэмжээгээр тооцож жилийн эцэст нэг удаа тус тус бодож олгохыг ерөнхий нягтланд үүрэг болгосугай.

Үүнд:

- ТУЗ-ийн даргын урамшууллыг 1 жилийн цалингийн хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнээр,
- ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, хараат бус гишүүдийн урамшууллыг 1 жилийн цалингийн хэмжээг 1 дахин нэмэгдүүлсэнээр,
- ТУЗ-ийн ердийн гишүүдийн урамшууллыг 1 жилийн цалингийн хэмжээг 0.5 дахин нэмэгдүүлсэнээр

3. Хурал хуралдуулахтай холбоотой удирдлагын зардлыг тухай бүрд тооцож олгохыг Гүйцэтгэх захирал Д.Нямбаярт зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА /Л.МЯГМАРЖАВ/